



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 он 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар ХТ/2996

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Сангийн сайд Б.Жавхлан хийх болсныг үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225017549



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 он 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар ХЗТ/2995

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2/... хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225017548

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ,
ГАДААД ҮНЭТ ЦААСНЫ ДАХИН САНХҮҮЖИЛТ, ӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮР ӨГӨӨЖ, ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ
БОЛОН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА,
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Нэг. Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын Засгийн газраас төсвийн алдагдлыг өндөр хүүтэй гадаад, дотоод арилжааны зээллэгээр нөхдөг байдлыг зогсоож, төсвийн сахилга бат, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах замаар төсвийн үргүй зардлыг бууруулах, төсвийн алдагдлыг багасгах болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулах бодлогыг баримтлан ажиллаж байна. Төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлж, богино хугацаатай, өндөр хүүтэй зээллэгээс татгалзан, нийгэм, эдийн засагт зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг урт хугацаатай, бага хүүтэй хөнгөлөлттэй эх үүсвэрээр санхүүжүүлж байна.

Засгийн газар нь Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу дунд хугацаанд буюу 3 жил тутам Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг Улсын Их Хурлаар батлуулж, хэрэгжүүлэн ажилладаг. Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг” нь төсвийн сахилга бат, санхүү, мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулж, шинээр зээллэг үүсгэх хэрэгцээ болон төсөвт учруулж болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах, дахин санхүүжилт хийхээс өөр зориулалтаар арилжааны нөхцөлтэй зээллэг авахгүй, шинээр Засгийн газрын өрийн баталгаа, барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ, өрийн бичиг гаргахгүй байх гэсэн зорилтуудыг тавьсан.

Энэхүү стратегийн баримт бичгийн дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилтууд амжилттай хэрэгжиж, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа үзүүлэлт 2016 онд 78.8 хувьтай тэнцэж байсан бол 2019 онд 55.1 хувь, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 50.1 хувь болж тус тус буурсан. Түүнчлэн Засгийн газрын өрийн жигнэсэн дундаж хүүгийн хэмжээ 2016 онд 5.3 хувьтай тэнцэж байсан бол 2019 онд 4.2 хувь, 2021 онд 3 хувьд хүрч буурсан бөгөөд эргэн төлөгдөх дундаж хугацаа 2016 онд 6 жилтэй тэнцэж байсан бол 2021 онд 8.3 жил болж уртассан болно.

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2016 онд 3,451.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2017 оноос хойш шинээр Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар 940.7 тэрбум төгрөг болж буурсан байна. Барих-шилжүүлэх төрлийн концессын нийт 2.4 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний гэрээг 2013 оноос 2017 оны хооронд байгуулсан байдаг бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 470.5 тэрбум төгрөгтэй тэнцэх үлдэгдэлтэй байна. Засгийн газрын векселийн гэрээг 2015 оноос эхлэн байгуулж эхэлсэн бөгөөд 2016 оны эцэст 307.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2017 он гэхэд векселийн төлбөрийг бүрэн төлж барагдуулан, ахиж векселийн гэрээ байгуулаагүй байна.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг шинээр хийхгүй байх бодлогыг баримталснаар Засгийн газрын өрийн хүүгийн төлбөр 2017 онд 1,156.5 тэрбум төгрөгтэй тэнцэж

байсан бол 2019 онд 861 тэрбум төгрөг, 2021 онд 826 тэрбум төгрөгтэй тэнцэж, тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын өрийн бүтцийн хувьд 2022 оны эхний хагас жилийн байдлаар 1.8 хувийг дотоод өр, 93.2 хувийг гадаад өр, 5.0 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, "барих-шилжүүлэх" концессын өр эзэлж байна. Засгийн газрын өр дэх арилжааны нөхцөлтэй зээлийн хэмжээг бууруулах зорилгоор богино хугацаатай, өндөр хүүтэй зээллэг хийхгүй байх, хугацаанаас нь өмнө төлж барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2016 онд Засгийн газрын өрийн 52.8 хувийг эзэлж байсан арилжааны нөхцөлтэй зээллэгийн эзлэх хувь 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 31.6 хувьд хүрч буурсан.

График 1. Засгийн газрын өрийн харьцаа, (2013-2022.II)



Засгийн газар өрийн үйлчилгээний зардлын, тэр дундаа хүүгийн төлбөрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах бодлого баримталсны үр дүнд 2016-2017 онд зээлийн хүүгийн зардал төсвийн орлогын 13.6-14.5 хувьтай, төсвийн зардлын 8.4-12.8 хувьтай тэнцэж байсан бол 2021 онд хүүгийн зардал төсвийн орлогын 6.0 хувь, төсвийн зардлын 5.3 хувь болж буурлаа.

Түүнчлэн Засгийн газрын өрийн үндсэн төлбөр төсөв, төрийн сангийн мөнгөн хөрөнгөд ихээхэн дарамт учруулж, 2016-2018 онд төсвийн орлогын 27.4-40.6 хувьтай, төсвийн зарлагын 16.9-35.8 хувьтай тэнцэж байсан бол 2021 онд төсвийн орлогын 11.7 хувь, төсвийн зарлагын 10.2 хувь болж буураад байна.

Засгийн газрын өрийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх дарамтыг ийнхүү бууруулахад 2017 оны 10 дугаар сараас богино хугацаатай, өндөр хүүтэй Засгийн газрын дотоод үнэт цаас гаргалтыг зогсоож, өндөр хүүтэй 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг буцаан худалдан авсан, гадаад өрийн зохицуулалтын үйл ажиллагааг шат дараатай авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд голлон нөлөөлсөн.

Хүснэгт 1. Засгийн газрын өрийн үйлчилгээний эдийн засаг, төсвийн үзүүлэлтүүдэд харьцуулсан харьцаа (2016-2021)

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Хүүгийн төлбөр (тэрбум төгрөг)	793.7	1,156.5	1,046.4	861.0	932.8	829.6
Төсвийн орлогод эзлэх хувь	13.6%	14.5%	10.3%	7.2%	8.7%	6.0%
Төсвийн зарлагад эзлэх хувь	8.4%	12.8%	11.2%	7.4%	6.4%	5.3%
ДНБ-д эзлэх хувь	3.3%	4.3%	3.3%	2.3%	2.4%	2.0%
Үндсэн төлбөр* (тэрбум төгрөг)	1,601.0	3,230.6	2,047.9	603.5	954.0	1,603.8
Төсвийн орлогод эзлэх хувь	27.4%	40.6%	20.1%	5.0%	8.9%	11.7%
Төсвийн зарлагад эзлэх хувь	16.9%	35.8%	22.0%	5.2%	6.5%	10.2%
ДНБ-д эзлэх хувь	6.7%	11.9%	6.4%	1.6%	2.5%	3.7%
Нийт өрийн үйлчилгээ (тэрбум төгрөг)	2,394.6	4,387.0	3,094.3	1,464.4	1,886.8	2,563.1
Төсвийн орлогод эзлэх хувь	41.0%	55.1%	30.4%	12.2%	17.6%	18.7%
Төсвийн зарлагад эзлэх хувь	25.2%	48.7%	33.2%	12.6%	12.9%	16.3%
ДНБ-д эзлэх хувь	10.0%	16.1%	9.6%	4.0%	4.9%	6.0%


* Үндсэн төлбөрт гадаад үнэт цаасны дахин санхүүжилт ороогүй болно.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн зорилтот үзүүлэлтүүдийг дэвшүүлсэн. Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж, холбогдох үйл ажиллагааг авч хэрэгжүүлсний үр дүнд өрийн зардлын үзүүлэлтүүд, дахин санхүүжилт болон хүүгийн түвшний эрсдэлийн үзүүлэлтүүд болон валютын эрсдэлийн үзүүлэлтүүд тус тус сайжирсан.

1.2. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл болон ДНБ-ий харьцаа үзүүлэлт 2013 оноос 2021 оныг хүртэл хэрхэн өөрчлөгдсөн талаар, мөн тус өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг дараах графикаар харуулав.

График 2. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс (2013-2021)



Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл, ДНБ-ий харьцаа 2013 оноос хойш тасралтгүй өсөж байсан бөгөөд 2016 онд 30 хувиар огцом нэмэгдэж байжээ. Үүнд төсвийн алдагдал 11.2 хувиар, төгрөгийн ханшийн сулрал 6.6 хувиар, бусад өр үүсгэгч хүчин зүйлс (төсөвт тусгагдаагүй барих-шилжүүлэх концесс, вексель зэрэг)-ээс шалтгаалж 8.6 хувиар тус тус өссөн байна. Харин 2017 оноос эхлэн ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжиж эхэлснээр арилжааны нөхцөлтэй зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүйгээс гадна төсвийн алдагдлыг богино хугацаатай, өндөр хүүтэй дотоод үнэт цаасаар санхүүжүүлж байсныг зогсоосон. Энэ хугацаанд Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх харьцаа (2017 оноос 2019 оны хооронд) 28.2 хувиар буурсан байна.

Засгийн газрын өр, ДНБ-ий харьцаа 2017-2019 онд ийнхүү 28.2 хувиар буурахад эдийн засгийн бодит өсөлтөөс шалтгаалж 10 хувь, бодит хүүгийн түвшнээр¹ 12.8 хувь, Засгийн газрын өрийн баталгааны өөрчлөлтөөр 12.4 хувь, төсвийн үндсэн тэнцлээр 0.6 хувиар тус тус нөлөөлсөн бол валютын ханшийн сулралаар 5.3 хувь, бусад өр үүсгэгч хүчин зүйлсээр 3.5 хувиар өссөн байна.

Хоёр. Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын нийт гадаад өр 2016 онд 24.6 тэрбум ам.доллартой тэнцэж, ДНБ-ий 256 хувьд хүрч байсан бол 2022 оны II улирлын байдлаар 33.3 тэрбум ам.долларт хүрч ДНБ-ий 220 хувьтай тэнцэж байна. Үүний 24.3 хувийг Засгийн газрын өр (8.1 тэрбум ам.доллар), 7.5 хувийг Монголбанкны өр төлбөр (2.5 тэрбум ам.доллар), 4.2 хувийг арилжааны банкны гадаад өр (1.4 тэрбум ам.доллар), үлдсэн 64.0 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бусад салбарын гадаад өр (21.3 тэрбум ам.доллар) эзэлж байна.

Улсын нийт гадаад өр 2016 онтой харьцуулахад ийнхүү өсөхөд бусад салбарын гадаад өр 5.8 тэрбум ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Тэр дундаа Оюутолгойн өр 2016 онд 7.4 тэрбум ам.доллар байснаас 2022 оны эхний хагас жилд 12.4 тэрбум ам.долларт хүрч өссөн байна.




График 3. Улсын нийт гадаад өр, тэрбум ам.доллар (2016-2022.II)

¹ Бодит хүүгийн түвшин нь нэрлэсэн хүүгийн түвшин болон инфляцийн зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Засгийн газрын гадаад өр 2016 онд 4.9 тэрбум ам.доллартой тэнцэж байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 8.1 тэрбум ам.доллартой тэнцэж байна. Үүнээс Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 5.6 тэрбум ам.доллар, Засгийн газрын гадаад үнэт цаасны² үлдэгдэл 2.4 тэрбум ам.доллартой тэнцэж байна. Харин 2016 онд Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2.1 тэрбум ам.доллар, Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2.8 тэрбум ам.доллартой тэнцэж байв.

Дээрх өсөлт (2016 оноос 2022 оны эхний хагас жилийн) нь Засгийн газрын үнэт цаасны хувьд Монгол Улсын Хөгжлийн банкны 2011 онд олон улсын зах зээлд арилжаалсан Засгийн газрын өрийн баталгаат 580 сая ам.доллартой тэнцэх хэмжээний "Евробонд"-ыг Засгийн газрын зүгээс "Хуралдай" үнэт цаасыг олон улсын зах зээлд 2017 онд арилжаалж төлсөн дүнгээр нэмэгдсэн байна.

Засгийн газрын гадаад зээлийн хувьд 2017 оноос эхлэн ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Япон Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газруудаас нийт 866.9 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийг, түүнчлэн 2020 онд КОВИД-19 цар тахлын эсрэг авах арга хэмжээнд зориулж Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ОУВС, Япон Улсын Засгийн газар зэрэг зээлдүүлэгч байгууллагуудаас нийт 933 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэрийг авч ашигласан. Эдийн засгийн хүндрэлийн үед авч ашигласан эдгээр хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүд нь тухайн цаг үеийн гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэн, төсөв, эдийн засагт түргэн шуурхай санхүүжилтээр хангаж байсан.

Дээрх шалтгаануудын улмаас Улсын нийт гадаад өрд орж буй Засгийн газрын гадаад өр 2016 оноос 2020 он хүртэл нийт 3.8 тэрбум ам.доллароор өсөж, 8.7 тэрбум ам.долларт хүрсэн байна. Гэсэн хэдий ч 2021 онд гадаад зээлийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан, 2016 онд авсан Кредит Свисс банкны 250 сая ам.долларын зээлийг бүрэн төлсөн, Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичигт тусгасны дагуу "Мазаалай" бондын үлдэгдэл төлбөрийг улсын төсвийн мөнгөн хөрөнгийн боломжит үлдэгдлээс төлсөн буюу гадаад бондын үлдэгдлийг бууруулсан зэргээс шалтгаалж 2021 оны жилийн эцэст 8.5 тэрбум ам.доллар, 2022 оны хагас жилийн байдлаар 8.1 тэрбум ам.долларт хүрч тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гурав. Засгийн газрын гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2022 оны хагас жилийн байдлаар 8,994.9 тэрбум төгрөг буюу 2,869.9 сая ам.доллартой тэнцэж байна. Үүнээс 2023 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй "Гэрэгэ" бондын хэмжээ 533.1 сая ам.доллар, 2024 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй "Хуралдай" бондын хэмжээ 600.0 сая ам.доллартой тэнцэж байгаа бөгөөд тус бондын төлбөрийг ирэх онуудад төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс боломжит хэмжээгээр төлж, үлдсэн хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

² Улсын нийт гадаад өрийн статистикт Засгийн газрын гадаад өр дэх үнэт цаасны үлдэгдлийг гаргахдаа дотоодын хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй үнэт цаасыг хасаж тооцдог болно.

Хүснэгт 2. Гадаад үнэт цаас, 2022.06.30

№	Гадаад үнэт цаас	Гаргасан хэмжээ /сая \$/	Гаргасан огноо	Хүү	Хугацаа	Үлдэгдэл /тэрбум ₮/
1	Чингис-2022	1,000.0	2012/12	5.125%	10 жил	428.7
2	Чингис-2017	500.0	2012/12	4.125%	5 жил	-
3	Дим Сам	161.2	2015/06	7.500%	3 жил	-
4	Мазаалай	500.0	2016/04	10.875%	5 жил	-
5	Хуралдай	600.0	2017/03	8.750%	7 жил	1,880.6
6	Гэрэгэ	800.0	2017/10	5.625%	5.5 жил	1,670.8
7	Номад	600.0	2020/09	5.125%	5.5 жил	1,880.6
8	Сенчири-2027	500.0	2021/06	3.500%	6 жил	1,567.1
9	Сенчири-2031	500.0	2021/06	4.450%	10 жил	1,567.1
НИЙТ		5,161.2				8,994.9

Засгийн газрын гадаад үнэт цаасны хувьд 2012-2016 оны хооронд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зорилгоор 1.5 тэрбум ам.долларын “Чингис” бонд, төсвийн алдагдал нөхөх зориулалтаар 161.2 сая ам.долларын “Дим Сам” бонд, 500 сая ам.долларын “Мазаалай” бондыг олон улсын зах зээлд арилжаалсан байдаг.

Түүнчлэн 2017 оноос эхлэн өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд буюу хугацаа нь тулсан гадаад бондын эргэн төлөлтийг дахин санхүүжүүлэх зориулалтаар 3.0 тэрбум ам.доллартой тэнцэх гадаад үнэт цаасыг арилжаалсан байна. Үүнд 2017 онд гаргасан 600.0 сая ам.доллартой тэнцэх “Хуралдай” бонд, 800.0 сая ам.доллартой тэнцэх “Гэрэгэ” бонд, 2020 онд арилжаалсан 600.0 сая ам.доллартой тэнцэх “Номад” бонд, 2021 онд арилжаалсан 1,000.0 сая ам.доллартой тэнцэх “Сенчири” бонд зэрэг өрийн зохицуулалтын арга хэмжээнүүд багтаж байна.

3.1. Чингис бонд

Улсын Их Хурлын 2012 оны “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” 52 дугаар тогтоолоор урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны Засгийн газрын үнэт цаасыг үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн. Энэ хүрээнд 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Чингис” төслийн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, 1.5 тэрбум ам.долларын үнэт цаасыг 2 транчтай, I транчийн хугацаа 5 жил, 4.125 хувийн хүүтэй, II транчийн хугацаа 10 жил, 5.125 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээлд тус тус арилжаалсан.

“Чингис” бондын зарцуулалтын тухай

“Чингис” бондын санхүүжилтийн 12.6 хувь буюу 325.3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг банкуудаар дамжуулан, 24.0 хувь буюу 620.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг шууд төсөлд олгосон бол үлдсэн 63.4 хувь буюу 1,637.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай 18 багц нийт 273 төсөлд хөрөнгө оруулах байдлаар зарцуулсан байна.

Банкуудаар дамжуулан олгосон зээлүүдийн хувьд хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дахь ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын чиглэлээрх

төслүүдэд нийт 168 зээлийн 269 тэрбум төгрөгийн зээл, харин ноолуурын салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалттай нийт 11 хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 54.2 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон. Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой 9 төсөлд нийт 620.9 тэрбум төгрөгийн зээлийг шууд олгосон байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай зээлийн хувьд дэд бүтцийн салбарт 269 төслийн хүрээнд 1.6 их наяд төгрөгтэй тэнцэх зээлийг, уул уурхайн салбарт 1 төслийн 2.6 тэрбум төгрөгийн зээлийг, хөдөө аж ахуйн салбарт 1 төслийн 8 тэрбум төгрөгийн зээлийг, үлдсэн 22 тэрбум төгрөгийн зээлийг бусад салбарын зээлүүдэд олгосон байна.

"Чингис" бонд нь төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилготой хамгийн анхны болон цорын ганц Засгийн газрын бонд боловч тухайн хөрөнгийг босгохоосоо өмнө юу хийх, ямар хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхээ эцэслээгүй, хөгжлийн бодлогын институт нь зээл, тусламж, бонд гэрээ байгуулах ажилд хэт их оролцсон нь бондын зарцуулалтын үр өгөөжийг бууруулсан байдаг.

Бондын эргэн төлөлтийн тухай

"Чингис" бондын хувьд эхний транч болох 500 сая ам.доллартой тэнцэх эргэн төлөлтийг 2018 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр төлсөн бол үлдсэн 1.0 тэрбум ам.доллартой тэнцэх транчийн үндсэн төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр төлөх хуваарьтай байсан. Үүнээс 2018 оны 1 дүгээр сард төлөгдөх хуваарьтай бондын I транчийг 5.5 жилийн хугацаатай, 5.625 хувийн хүүтэй "Гэрэгэ" өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд төлж барагдуулсан бол 2022 онд төлөгдөх хуваарьтай II транчийн хувьд 2020 онд "Номад" өрийн зохицуулалтын хүрээнд 200.8 сая ам.долларыг, 2021 онд "Сенчири" өрийн зохицуулалтын хүрээнд 662.4 сая ам.долларыг төлж, 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 136.8 сая ам.долларыг улсын төсвөөс бүрэн төлж барагдуулаад байна.

"Чингис" бондын зөвхөн хүүгийн төлбөрт 2012 оноос 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хооронд нийт 540.9 сая ам.долларын төлбөрийг төлсөн байдаг.

3.2. Дим Сам бонд

Засгийн газрын 2015 оны 217 дугаар тогтоолын дагуу төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, төсвийн ачааллыг жигдлэх зорилгоор 1 тэрбум юанийн "Дим Сам" бондыг 3 жилийн хугацаатай, 7.5 хувийн хүүтэйгээр 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр олон улсын зах зээлд арилжаалсан. Тус бондын хүрээнд нийт 25.7 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн бөгөөд 2018 оны 6 дугаар сард "Гэрэгэ" өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд төлж барагдуулсан.

3.3. Мазаалай бонд

Засгийн газрын 2016 оны 17 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах зорилгоор 500 сая ам.долларын "Мазаалай" бондыг 5 жилийн хугацаатай, 10.875 хувийн хүүтэйгээр 2016 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр олон улсын зах зээлд арилжаалсан. Тус бондын хүрээнд нийт 251.9 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хүүгийн төлбөр төлсөн бөгөөд 2020 онд гаргасан "Номад" бондын хүрээнд 367.2 сая ам.доллартой тэнцэх хэсгийг өрийн

зохицуулалтаар төлж, үлдэх 132.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 2021 оны 4 дүгээр сард төлж дуусгасан байдаг.

3.4. Хуралдай бонд

Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын өрийн баталгаат, Монгол Улсын Хөгжлийн банкны 2011 онд гаргасан 580 сая ам.долларын "Евробонд"-ыг дахин санхүүжүүлэх зорилгоор 600 сая ам.долларын "Хуралдай" бондыг 8.75 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатайгаар олон улсын зах зээлд арилжаалсан байдаг. Тус бондын хүрээнд нийт 288.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хүүгийн төлбөр төлсөн бөгөөд 2024 оны 3 дугаар сард эргэн төлөгдөх хуваарьтай байна.

Ингэснээр Засгийн газар Монгол Улсын Хөгжлийн банкны өрийг төлж барагдуулсан тул өр, авлагын харилцаа үүсч, улмаар Улсын Их Хурлын 2016 оны 81 дүгээр тогтоолын хүрээнд Хөгжлийн банкны дүрмийн санг нэмэгдүүлэх 1 их наяд төгрөг болон Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй өр, авлагын тооцоогоор суутган тооцож хаасан байдаг.

3.5. Гэрэгэ бонд

Засгийн газрын 2017 оны 228 дугаар тогтоолын дагуу өрийг дахин санхүүжүүлэх, өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх ачааллыг урт хугацаанд жигдлэх, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах зорилгоор 800 сая ам.долларын "Гэрэгэ" бондыг 5.625 хувийн хүүтэй, 5.5 жилийн хугацаатайгаар олон улсын зах зээлд арилжаалсан. Тус бондыг гаргаснаар 2012 онд гаргасан "Чингис" бондын 500 сая ам.доллар, 2015 онд гаргасан "Дим Сам" бондын 161.2 сая ам.долларын эргэн төлөлтийн хувьд өрийн зохицуулалт хийсэн.

Энэхүү бонд нь 2023 оны 5 дугаар сард төлөгдөх хуваарьтай бөгөөд 2021 онд авч хэрэгжүүлсэн "Сенчири" өрийн зохицуулалтын хүрээнд 266.9 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг буцаан худалдаж авч, 533.1 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна. Түүнчлэн, "Гэрэгэ" бондын хүрээнд 2022 оны хагас жилийн байдлаар нийт 205.4 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хүүгийн төлбөрийг төлөөд байна.

3.6. Номад бонд

Засгийн газрын зүгээс Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 600.0 сая ам.долларын 5.125 хувийн купонтой "Номад" бондыг арилжаалж, улмаар 2021 онд төлөгдөх 10.875 хувийн купонтой "Мазаалай" бондын 367.2 сая ам.доллар, 2022 онд төлөгдөх 5.125 хувийн купонтой "Чингис" бондын 200.8 сая ам.доллартой тэнцэх хэсгийг буцаан худалдан авсан. Энэхүү бондын хүрээнд нийт хүүгийн төлбөрт 61.5 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хүүгийн төлбөрийг төлөөд байна.

3.7. Сенчири бонд

Засгийн газрын зүгээс Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор

2021 онд “Сенчири” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан 2012 онд гаргасан “Чингис” бонд болон 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын өр төлбөрийн тодорхой хувийг дахин санхүүжилт хийж, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай, 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай, 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өр төлбөрийг шийдвэрлэсэн.


“Сенчири” өрийн зохицуулалтын арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлснээр Засгийн газрын гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрийг 21.0 сая ам.доллараар хэмнэж, 2022-2023 онуудад гадаад валютын 1,000.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний нөөцийг хадгалж үлдсэн.

3.8. Зээлжих зэрэглэл

Монгол Улсын Сангийн яам олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс агентлагтай 1999 оноос, Фитч Рэйтингс болон Мүүдис агентлагтай 2005 оноос Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтоолгох чиглэлээр хамтран ажиллаж эхэлсэн. Улсын зээлжих зэрэглэл нь тухайн улс гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээлийн төлбөрөө ирээдүйд эргэн төлөх чадвар, эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм. Эдгээр агентлагууд улсын зээлжих зэрэглэлийг өөрсдийн тогтсон аргачлалын дагуу улсын эдийн засгийн өсөлт, төлөв байдлаас гадна төсвийн сахилга бат, өрийн удирдлага, санхүүгийн болон эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалт, гадаад секторын нөхцөл байдал, улс төр, нийгэм болон засаглалын орчин зэрэг хүчин зүйлсэд үндэслэн тогтоодог.

Стандарт энд Пүүрс болон Фитч агентлаг 2018 оноос хойш Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B, тогтвортой” гэж үнэлснээс хойш жил бүр тогтвортой хэвээр хадгалж ирсэн. Харин Мүүдис агентлаг зээлжих зэрэглэлийг 2020 онд “B3, сөрөг” төлөв рүү оруулаад байсан ч 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр төлөвийг эргүүлэн “тогтвортой” гэж үнэлсэн. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2007-2013 онуудад Стандарт энд Пүүрс агентлаг хамгийн өндөр буюу “BB-” түвшинд үнэлж байсан.

График 4. Монгол Улсын зээлжих зэрэглэл (2016-2022)



Гадаад валютын албан нөөц нэмэгдэх, төсвийн алдагдал буурах, Засгийн газрын өр буурах, өрийн удирдлагын зохистой бодлогыг хэрэгжүүлэх замаар өрийн дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, гадаад өрийн хэмжээг тогтвортой

хэмжээнд барих, эдийн засгийн өсөлт болон экспортыг тогтвортой байлгах зэрэг нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад гол зэрэг нөлөөг үзүүлдэг. Харин зээлжих зэрэглэл буурахад дээрх хүчин зүйлсээс гадна Монгол Улсын төсвийн сахилга бат алдагдах, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн томоохон төслүүд зогсох, нийгмийн болон улс төрийн тогтворгүй байдал зэрэг нь сөргөөр нөлөөлж байдаг.

Мүүдиз агентлаг 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн ээлжит үнэлгээг гүйцэтгэн, улмаар зээлжих зэрэглэлийг "B3" хэвээр хадгалж, төлөвийг "сөрөг"-өөс "тогтвортой" болгосон. КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллөөр буураад байсан Монгол Улсын эдийн засаг тогтворжиж, экспорт 2020 оны 2 дугаар хагаст сэргэж эхэлсэн төдийгүй Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаа зэрэг нь зээлжих зэрэглэлийн төлөвийг "тогтвортой" болгоход чухал нөлөө үзүүлсэн байна.

3.9. Олон улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал

КОВИД-19 цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийг тогтворжуулах, хурдацтай нэмэгдэж буй инфляцын түвшнийг бууруулах, эрчим хүч, хүнсний барааны үнийн өсөлтийг намжаах зорилгоор хөгжингүй орнуудын Төв банкнаас хэрэгжүүлж байгаа мөнгөний хатуу бодлого, АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны хүүгийн өсөлт, ОХУ болон Украин улс хоорондын мөргөлдөөн, БНХАУ-ын Тэг-Ковид бодлогын нөлөө зэргээс үүдэн олон улсын хөрөнгийн зах зээлд томоохон уналт бий болж, улмаар Шри-Ланка Улс дефолт зарлан, Пакистан Улс дефолт зарлах өндөр магадлалтай байна. Эдгээр нөхцөл байдлаас хамаарч хөрөнгө оруулагчид хөгжиж буй зах зээлээс хөрөнгөө татан, ирэх онд эдийн засаг, санхүүгийн хямрал дэлхийн зах зээлд тохиож магадгүй гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн энэхүү уналт болон Монгол Улсын өнөөгийн үүсээд буй эдийн засгийн хүнд нөхцөл байдал, төлбөрийн тэнцлийн алдагдал 1.5 тэрбум ам.доллар, инфляц 13.8 хувьд хүрсэн, гадаад валютын албан нөөц 2.7 тэрбум ам.доллар болж огцом буурсан, гадаад валютын ханш огцом нэмэгдэж, валютын орох урсгал багассан, мөн дээрх нөхцөл байдлын талаарх нийтлэл Блүүмберг платформ дээр 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр гарснаас Монгол Улсын Засгийн газрын гадаад үнэт цаасны үнэ огцом буурч, хоёрдогч зах зээл дэх өгөөж 40 хувьд хүрч огцом өсөж байсан.

Харин ойрын хугацаанд Монгол Улсын гадаад валютын нөөц өсөх төлөвтөө орж, "Чингис" бондын төлбөрийг бүрэн төлж барагдуулсан бөгөөд 2023 онд төлөгдөх нөхцөлтэй "Самурай" бондын эх үүсвэрийг бүрдүүлсэн зэрэг зэрэг мэдээллүүд цацагдсанаар 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдөр гэхэд "Гэрэгэ" бондын өгөөж 13 хувь, "Сенчири" бондын өгөөж 8 хувьд тус тус хүрч, тогтворжиж эхлээд байна.

Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх "Гэрэгэ" бондын 16.3 сая ам.доллар, "Чингис" бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.8 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргасан. Түүнчлэн зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалах, харилцааг сайжруулах ажлын хүрээнд тэдэнд Монгол Улсын нийгэм, эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээллийг тогтмол хүргэж, биет болон цахим уулзалтуудыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.

Дөрөв. Засгийн газрын гадаад зээлийн зарцуулалт ба үр өгөөж

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш нийт 326 төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зориулалтаар 7.7 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг авч ашигласан бөгөөд үүнээс 5.1 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төслийн зээлд буюу 290 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан бол төсвийн дэмжлэгийн зориулалтаар 2.6 тэрбум ам.доллартой тэнцэх 36 хөтөлбөрийн зээлийн хөрөнгийг авч ашигласан байдаг.

Төслийн зээлийн 3.2 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг нийгмийн шинж чанартай, эргэн төлөгдөхгүй 169 төслийн зээлд, 1.9 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг эдийн засгийн үр өгөөжтэй, дотоодод дамжуулан зээлдүүлэх 121 төслийн зээлд зарцуулсан.

Хүснэгт 3. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төслүүд, 2022.06.30

№	Зээлдүүлэгч	Нийт хэрэгжсэн төсөл	Хэрэгжсэн дундаж хугацаа /жил/	Ашиглалт /сая \$/
1	Азийн хөгжлийн банк	46	10	776.9
2	Дэлхийн банк	34	9	463.1
3	Герман	23	10	152.4
4	Япон	27	9	1,146.8
5	БНХАУ	18	10	694.3
6	Солонгос	11	7	71.0
7	Австри	7	5	51.9
8	Польш	5	5	37.2
9	Норвеги	5	9	34.3
10	Кувейт сан	4	6	81.4
11	Франц	3	6	20.5
12	Беларусь	3	2	23.4
13	ХААХОУСан	3	10	30.3
14	Швед	3	9	5.8
15	Европын хөрөнгө оруулалтын банк	2	9	28.7
16	Испани	2	6	16.9
17	Абу-Даби сан	1	3	13.0
18	Бельги	1	11	6.5
19	Энэтхэг	1	2	1.8
20	Бусад	4	3	103.3
	Нийт	203	8	3,759.6

1991 оноос хойш авч ашигласан нийт гадаад зээлийн хөрөнгийн 51.9 хувийг хөгжлийн түнш олон улсын байгууллага, 49.1 хувийг хөгжлийн түнш улс орнууд бүрдүүлсэн байна. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны 2.3 тэрбум ам.долларын санхүүжилтээр 101 төсөл, Дэлхийн банкны 1.0 тэрбум ам.долларын санхүүжилтээр 55 төсөл, ОУВС-ийн 0.5 тэрбум ам.долларын санхүүжилтээр 13 төсөл, хөтөлбөр санхүүжүүлсэн бол Япон Улсын Засгийн газрын 1.8 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 26 төсөл, БНХАУ-ын 1.1 тэрбум ам.долларын санхүүжилтээр 23 төсөл, БНСУ-ын 0.2 тэрбум ам.долларын санхүүжилтээр 19 төсөл, бусад хөгжлийн түнш, улс орнуудын нийт 0.6 тэрбум ам.долларын санхүүжилтээр 75 төсөл тус тус хэрэгжүүлсэн.

Түүнчлэн төслийн зээлийн 5.1 тэрбум ам.долларын ашиглалтын 66 хувь буюу 3.4 тэрбум ам.доллар биет хөрөнгө буюу барилга, тоног төхөөрөмж болж үлдсэн бол 34 хувь нь зөвлөх үйлчилгээ, үйл ажиллагааны болон магадлашгүй зардал, шимтгэл зэрэгт зарцуулагдсан байна. Эдгээр төслүүдийн дийлэнх хувь (45 хувь)-ийг дэд бүтцийн буюу агаарын тээвэр, боомт, төмөр зам, авто зам, орон сууц, инженерийн шугам сүлжээний салбар эзэлж байгаа бол худалдаа, эдийн засаг 14 хувь, эрчим хүч 12 хувь, эрүүл мэнд 8 хувь, хөдөө аж ахуй, уул уурхай, нийгмийн хамгааллын салбарууд 5 хувь, боловсрол 4 хувь, харилцаа холбооны салбар 3 хувийг тус тус бүрдүүлдэг.

Дээрх төслүүдээс 203 нь 1990-2022 оны хооронд 3.8 тэрбум ам.долларын санхүүжилтээр бүрэн хэрэгжиж дууссан бол 2018-2026 оны хооронд хэрэгжүүлэх 123 төслийн хүрээнд 1.3 тэрбум ам.долларыг авч ашиглаад байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн явц, гүйцэтгэл

Монгол Улсын 2022 оны төсөвт гадаад зээл, тусламжийн 158 төслийг санхүүжүүлэхээр нийт 1,606.1 тэрбум төгрөг батлагдсанаас 2022 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар 1,348.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл 84 хувьтай байгаа бол 2023 онд 140 төслийг санхүүжүүлэхээр нийт 1,795.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр 2023 төсөвт батлагдсан.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн зарлага нийт төсвийн зарлагын дунджаар 10-12 хувийг эзэлдэг бөгөөд сүүлийн 5 жилийн гүйцэтгэлийн дундаж 94 хувьтай байна. Цаашид хэрэгжиж буй төслүүдийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж дуусгахын тулд жилд дунджаар 3.4 их наяд төгрөгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлах шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагатай хамтран 2022 онд хэрэгжүүлж байгаа болон хэлэлцээрийн шатанд байгаа гадаад зээл, тусламжийн төсөл арга, хэмжээний нийт амлалтын дүн 25.7 их наяд төгрөг байгаа бөгөөд зарцуулаагүй үлдэгдэл 20.8 их наяд төгрөг буюу ашиглалт 20 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цаашид шинэ төсөл эхлүүлэхээс илүүтэй хэрэгжиж байгаа төслүүдээ төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж дуусгах шаардлагатай байгааг харуулж байна. Түүнчлэн тухайн салбарт хэрэгжиж байгаа 4 төсөл тутмын 1 нь хугацаа сунгаж, хэрэгжилтийн хугацааг 5 болон түүнээс дээш жилээр сунгах төлөвтэй байгаа тул одоогийн байдлаар санхүүжилтийн ашиглалт нь 30 хувиас доош байгаа Төсвийн ерөнхийлөн захирагч нар төслүүдийн хэрэгжилтэд анхаарах шаардлагатай байна.

Хүснэгт 4. Гадаад зээлийн ашиглалт, Төсвийн ерөнхийлөн захирагчаар, 2022.06.30

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл	Хугацаа сунгасан		Хэрэгжих дундаж хугацаа, жилээр /сунгаснаар/	Амлалтын дүн /сая \$/	Зарцуулаагүй үлдэгдэл /сая \$/	Ашиглалт %
			төсөл	%				
1	Нийслэлийн Засаг дарга	24	12	50%	5	962.53	774.16	20%
2	Барилга, хот байгуулалтын сайд	13	4	31%	6	708.21	502.67	29%
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	9	4	44%	6	232.14	155.10	33%
4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	5	4	80%	3	141.83	59.51	58%
5	Сангийн сайд	9	5	56%	5	241.18	186.71	23%
6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	12	3	25%	6	353.80	276.14	22%
7	Хууль зүй, дотоод хэргийн сайд	4	2	50%	4	69.41	68.11	2%
8	Эрүүл мэндийн сайд	16	2	12%	3	342.41	202.72	41%
9	Эрчим хүчний сайд	10	4	40%	5	752.00	674.27	10%
10	Шадар сайд	4	1	25%	5	125.17	85.16	32%
11	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	4		-	5	81.60	79.95	2%
12	Зам, тээврийн хөгжлийн сайд	6	1	17%	5	510.59	319.43	37%
13	Орон нутгийн Засаг дарга нар	3	1	33%	6	23.80	15.55	43%
14	Ерөнхий сайд	1		0%	4	21.10	21.10	0%
15	Засгийн газрын Эрхэг эрхлэх газрын дарга	1	1	100%	7	16.68	3.73	78%
16	Батлан хамгаалахын сайд	1		0%	3	8.14	5.70	30%
17	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	1	1	100%	9	1,236.00	1,183.19	4%
НИЙТ		123	45	37%	5	5,826.57	4,496.87	23%

Засгийн газрын зүгээс 2017 оноос 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд олон улсын санхүүгийн байгууллагууд болон хоёр талт зээлдүүлэгч улсуудаас төсвийн дэмжлэг хэлбэрээр нийт 1,957.4 сая ам.долларын хөнгөлөлттэй гадаад зээлийг авч ашигласан.

Үүнээс ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 300.0 сая ам.доллар (15-25 жилийн хугацаатай, хөвөгч хүүтэй), Дэлхийн банкнаас 222.9 сая ам.доллар (25 жилийн хугацаатай, 2 хувийн хүүтэй), Япон Улсын Засгийн газраас 284.0 сая ам.доллар (20 жилийн хугацаатай, 0.8 хувийн хүүтэй), БНСУ-ын Засгийн газраас 60.0 сая ам.доллар (20 жилийн хугацаатай, 1.5 хувийн хүүтэй)-ын төсвийн дэмжлэгийн зээлийг тус тус авч ашигласан.

Мөн ОУВС-ийн "Түргэвчилсэн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд 99.5 сая ам.доллар, КОВИД-19 цар тахлаас сэргийлэх, сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны 100.0 сая ам.долларын зээлийг 2020 онд тус тус авч ашиглаад байна.

Тав. Засгийн газрын өрийн баталгааны талаар

Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 2 дугаар сард батлагдсанаар Засгийн газрын өрийн баталгаа гаргахад баталгаа гаргуулагч болон төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хуульчилж, өрийн баталгаа гаргуулах хүсэлтэд эрсдэлийн үнэлгээ хийх, төсөл, арга хэмжээнд хяналт тавих зэрэг хууль эрх зүйн орчин бүрдсэн.

Энэхүү зохицуулалтад баталгаа гаргуулагч байгууллага нь сүүлийн 3 жил ашигтай ажилласан, хугацаа хэтэрсэн өргүй, зээлдүүлэгч байгууллагатай нэгдмэл сонирхолгүй, хэрэгжүүлж буй төслийн бэлтгэл ажил хангагдсан буюу техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн байх, холбогдох мэдээлэл, тайлан тооцоо, баримт бичгийг бүрдүүлсэн, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай байх зэрэг шаардлагуудыг хангахаар тусгасан. Ингэснээр Засгийн газрын буюу төсөвт учирч буй болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах хөшүүрэг болж өгсөн.

Хүснэгт 5. Засгийн газрын өрийн баталгаа, нийт гаргасан

№	Баталгаа гаргуулагч	Баталгаа гаргасан огноо	Дүн (сая нэгж)	Валют	Хүү	Хугацаа	Тайлбар
1	Хөгжлийн банк	2012.03.21	580.0	ам.доллар	5.75%	5 жил	Төлөгдсөн
2	МИАТ	2013.12.24	77.5	ам.доллар	2.52%	10 жил	Төлөгдсөн
3	МИАТ	2013.12.24	24.0	ам.доллар	5.3+LIBOR	7 жил	Төлөгдсөн
4	МИАТ	2013.12.24	20.0	ам.доллар	9.38+LIBOR	5 жил	Төлөгдсөн
5	Хөгжлийн банк	2014.01.06	30,000.0	иен	1.52%	10 жил	2023 онд төлөгдөж дуусна
6	Хөгжлийн банк	2014.09.03	162.0	ам.доллар	6.00%	8 жил	Төлөгдсөн
7	Хөгжлийн банк	2014.09.05	300.0	ам.доллар	4.25%+LIBOR	5 жил	Төлөгдсөн
8	Худалдаа хөгжлийн банк	2015.05.19	500.0	ам.доллар	9.375%	5 жил	Төлөгдсөн
9	Хөгжлийн банк	2016.04.19	65.4	ам.доллар	5.75%+LIBOR	3 жил	Төлөгдсөн
10	Эрдэнэс Монгол	2016.04.01	35.0	ам.доллар	0.5%+LIBOR	15 жил	2031 онд төлөгдөж дуусна
11	Шатахуун импортлогч 8 ААН	2022.04.20	236,444.1	төгрөг	12%	3 сар	Төлөгдсөн
		Нийт	2,048.9	сая ам.доллар			

5.1. Хөгжлийн банкны дунд хугацааны евро бонд - Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 580.0 сая ам.долларын, жилийн 5.75 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, Засгийн газрын баталгаатай үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр олон улсын зах зээлд арилжаалсан. Тус үнэт цаасыг 2017 оны 3 дугаар сард "Хуралдай" өрийн зохицуулалтын хүрээнд төлж барагдуулсан.

5.2. Самурай бонд - Монгол Улсын Хөгжлийн банкны 30.0 тэрбум иентэй тэнцэх хэмжээний 10 жилийн хугацаатай "Самурай" үнэт цаасыг Япон Улсын зах зээлд Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (JBIC)-ны баталгаатайгаар

жилийн 1.52 хувийн хүүтэйгээр арилжаалсан. Хөрөнгө оруулагчидтай хийсэн бонд арилжаалах гэрээний дагуу "Самурай" бондын эх үүсвэр 2014 оны 1 дүгээр сард Хөгжлийн банкны холбогдох дансанд шилжин орж ирсэн. "Самурай" бондын үндсэн төлбөрийг 2023 оны 12 дугаар сард төлөх хуваарьтай байна.

Самурай бондыг төлөх валютыг Монгол Улсын Хөгжлийн банкны олгосон зээлийн эргэн төлөлтийн хуримтлагдсан эх үүсвэрээс бүрдүүлж, Монголбанкинд Японы иений валютаар бүрэн байршуулаад байна. Хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн банк нь нэгэн цогц санхүүгийн систем болж тооцогддог тул Хөгжлийн банкны дахин санхүүжилтийн эрсдэлээс сэргийлж, эх үүсвэрийг бүрэн нөөцөлж чадсан энэхүү арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсад итгэх итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой болж байгаа юм.

5.3. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл - Монгол Улсын Хөгжлийн банк болон БНХАУ-ын Хөгжлийн банк хоорондын 162.0 сая ам.доллартой тэнцэх зээлд Монгол Улсын Засгийн газрын зүгээс 2014 онд баталгаа гаргасан. Тус зээлийн хугацаа нь 8 жил, зээлийн хүү нь жилийн тогтмол 6 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил байсан. Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс хуваарийн дагуу тус зээлийн эх үүсвэрийг 2023 онд төлж дуусгах хуваарьтай байсан бол 2022 оны 9 дүгээр сард буюу хуваарьт хугацаанаас өмнө зээлийн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

5.4. Кредит Свисс банкны зээл - Монгол Улсын Хөгжлийн банк, Кредит Свисс банк хоорондын 300.0 сая ам.доллартой тэнцэх зээлд Засгийн газар 2014 онд баталгаа гаргасан. Энэхүү зээл нь 7 жилийн хугацаатай ба эхний 2 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байсан. Зээлийн хүү хөвөгч буюу 6 сарын хугацаатай LIBOR дээр 4.375 хувийн нэмэгдэлтэй байсан. Ингэснээр зээлийн үндсэн хугацаа болох 4 жил 6 сарын хугацаанд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлж, 2021 онд зээл хаагдсан болно.

5.5. Боинг нисэх онгоц худалдан авах зээл - "МИАТ" ТӨХК болон АНУ-ын ЭКСИМ банк, ING CAPITAL LLC хоорондын 121.4 сая ам.доллартой тэнцэх зээлд Засгийн газраас 2013 онд баталгаа гаргасан бөгөөд Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авах зориулалттай зээл нь дараах 3 дэд зээлд хуваагддаг. Үүнд:

1. АНУ-ын ЭКСИМ банканд 77.4 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, жилийн 2.52 хувийн тогтмол хүүтэй, 10 жилийн хугацаатай зээл;

2. ING CAPITAL LLC банканд 23.9 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, хүү нь хөвөгч буюу 3 сарын хугацаатай LIBOR дээр 5.3 хувийн нэмэгдэлтэй, 7 жилийн хугацаатай зээл;

3. ING CAPITAL LLC банканд 20.0 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, хүү нь хөвөгч хүү буюу 3 сарын хугацаатай LIBOR дээр 9.38 хувийн нэмэгдэлтэй, 5 жилийн хугацаатай зээл.

Түүнчлэн агаарын хөлөг худалдан авахад зориулж Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банкны хооронд 2014 онд байгуулсан Батлан даалтын гэрээ болон 2015 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн гэрээний дагуу Сангийн яам "МИАТ" ТӨХК-ийн өмнөөс зээлийн төлбөрийн батлан даалт гаргасан. Тус зээлийн эх үүсвэрийн сүүлийн эргэн төлөлтийг 2023 онд хийх хуваарьтай байсан бол баталгаа гаргуулагч "МИАТ" ТӨХК-ийн зүгээс 2022 оны 6 дугаар сард хугацаанаас өмнө бүрэн төлж барагдуулаад байна.

5.6. Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан бонд - Худалдаа хөгжлийн банкны Глобал үнэт цаасны хөтөлбөрийн хүрээнд олон улсын зах зээлд арилжаалсан 5 жилийн хугацаатай 500.0 сая ам.долларын бондод баталгаа гаргасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-д Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг “Засгийн газрын өрийн хязгаар”-т оруулахгүйгээр заасан тул тус баталгаа нь өрийн хязгаарт тооцогдоогүй.

Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т Баталгаа гаргуулагч нь гадаад зээллэгтэйгээ тэнцүү хэмжээгээр өөрийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасыг барьцаалсан буюу баталгаажуулсан тохиолдолд тухайн зээллэгийн нийт дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болох бөгөөд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг баталгаа гаргуулагч этгээд хариуцахаар баталгааны гэрээнд тусгана гэж заасны дагуу Худалдаа хөгжлийн банкнаас 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 1.0 их наяд төгрөгийн нэрлэсэн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг барьцаалах замаар Засгийн газрын баталгаа гаргуулсан.

Баталгаа гаргуулагчийн зүгээс энэхүү үнэт цаасны төлбөрийг 2020 оны 5 дугаар сард хийж дуусгасан болно.

5.7. Азийн хөгжлийн банкнаас олгосон техник туслалцааны зээл - Азийн хөгжлийн банк болон “Эрдэнэс Монгол” ХХК хоорондын 35.0 сая ам.доллартой тэнцэх, хөвөгч хүү буюу 6 сарын хугацаатай LIBOR дээр 0.6 хувийн нэмэгдэлтэй тэнцэх хэмжээний хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлд Засгийн газар 2016 онд өрийн баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2021 оны хагас жилийн байдлаар 9.3 сая ам.доллар байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

5.8. Шатахууны импортын урьдчилгаа төлбөрт гаргасан Засгийн газрын өрийн баталгаа - Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6.1.3-т “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарын хүрээнд энэ хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах” гэж заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолын дагуу газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдийн ОХУ-ын “Роснефт” НХН-ээс АИ-92 автобензин худалдан авах зориулалтаар ондоо эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр арилжааны банкуудаас авах зээлийн эргэн төлөлтөд Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай Засгийн газрын 2022 оны 160 дугаар тогтоол гарсан.

Тухайн үед бүтээгдэхүүний хил үнийн өсөлтөөс үүдэн өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн жижиглэнгийн үнэ 2022 оны 4 дүгээр сард зарагдаж байсан үнэ (2390 төгрөг)-ээс 900 орчим төгрөгөөр нэмэгдэх нөхцөл байдал үүссэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ОХУ-ын “Роснефть” НХН-тэй хэлэлцээр хийж, АИ-92 автобензинийн хил үнэ болох 1110 ам.доллар/тонн-ыг 840 ам.доллар болгон бууруулсан бөгөөд энэхүү хэлэлцээрийн гол нөхцөл нь 4, 5, 6 дугаар саруудын нийт хэрэглээ буюу 120.0 мянган тонн бүтээгдэхүүний захиалгын төлбөр болох 100.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний эх үүсвэрийг урьдчилан төлөх нөхцөлтэй байсан.

Засгийн газрын 2022 оны 160 дугаар тогтоолын дагуу “Роснефть” НХН-тэй худалдан авах гэрээ байгуулсан 14 компани Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлт ирүүлснээс шатахуун импортлогч 8 компанийн зээлд нийт 236.4 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр бүх зээл төлөгдөж, Засгийн газрын өрийн баталгааны гэрээний хамт дуусгавар болсон.


Зургаа. Засгийн газрын дотоод өрийн талаар

6.1. Засгийн газрын дотоод үнэт цаас

Засгийн газрын зүгээс санхүүгийн зах зээлийг дэмжих, үнэт цаасны өгөөжийн муруй буюу зах зээлийн жишиг хүүгийн түвшинг тогтоох, төсөвт шаардлагатай байгаа мөнгөн хөрөнгийн дутагдлыг түргэн хугацаанд санхүүжүүлэх зорилгоор 2012 оны 12 дугаар сараас Засгийн газрын үнэт цаасны нээлттэй арилжааг долоо хоног бүр Монголбанкны системээр дамжуулан тогтмол зохион байгуулж эхэлсэн.

Түүнчлэн үнэт цаасны зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, зах зээлд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, иргэд чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлэх, цаашлаад санхүүгийн зах зээлийг төрөлжүүлэх зорилгоор Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны арилжааг 2014 оны 11 дүгээр сараас долоо хоног бүр Монголын хөрөнгийн биржээр арилжаалж эхэлсэн. Ингэснээр 2016 оны жилийн эцэст дотоод үнэт цаасны үлдэгдэл 5.5 их наяд төгрөгт буюу 1990 оноос хойш хамгийн өндөр хэмжээнд хүрч байсан.

График 5. Засгийн газрын дотоод үнэт цаас, тэрбум ₮, 2012-2022.11



Сайн хөтөлбөрийн хүрээнд арилжаалсан дотоод үнэт цаас

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 114, 229, 312, 334 дүгээр тогтоолын дагуу 2016 онд “Сайн малчин”, “Сайн оюутан”, “Сайн хашаа”, “Сайн хувьцаа” хөтөлбөрүүдийг тус тус хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг санхүүжүүлэх зорилгоор “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд 3 жилийн хугацаатай нийт 200.0 тэрбум төгрөгийн үнэт цаас, “Сайн оюутан” хөтөлбөрийн хүрээнд 1, 1.5, 10 жилийн хугацаатай нийт 11.0 тэрбум төгрөгийн үнэт цаас, “Сайн хашаа”

хөтөлбөрийн хүрээнд нийт 11 тэрбум төгрөгийн 5 жилийн хугацаатай үнэт цаас, "Сайн хувьцаа" хөтөлбөрийн хүрээнд 15 жилийн хугацаатай 374.0 тэрбум төгрөгийн үнэт цаас, нийт 596.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг дотоодын арилжааны банкуудад арилжаалсан байдаг. Энэхүү үнэт цаасны үлдэгдэл 2022 оны хагас жилийн байдлаар 209 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

"Сайн малчин" хөтөлбөр

Арилжааны банкаар дамжуулан малчдад олгох зээлийн хүүгийн түвшнийг бууруулах замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, банк, малчин, үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, үйлдвэрлэлийн бүтээмж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэн экспортыг нэмэгдүүлэх замаар малчид, фермер эрхлэгчдийн орлого, амьжиргааг сайжруулах зорилгоор "Сайн малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд зээлийн хүүгийн түвшнийг 10 хүртэл хувь болгон бууруулсан бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс хойш Төрийн банк болон Хаан банкинд нийт 38,633 малчин 150.3 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 10 хувийн хүүтэйгээр авах хүсэлт ирүүлснээс 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн эцсийн байдлаар нийт 36,073 малчинд 138.8 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 10 хувийн хүүтэй олгосон байдаг.

Хөтөлбөрт зориулж санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 200.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар гаргасан бөгөөд энэхүү үнэт цаасыг 2018 онд төлж барагдуулсан.

"Сайн оюутан" хөтөлбөр

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа оюутны хариуцлагыг дээшлүүлж, түүний өрсөлдөх чадвар, сурах бололцоог нэмэгдүүлэн, оюутны сургалтын төлбөрийн зээлийн нөхцөлийг сайжруулах юм. "Сайн оюутан" хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлбөрт зориулан авсан цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдлийг шинэ нөхцөлтэй зээлд шилжүүлэх, оюутанд сургалтын төлбөрийн богино болон урт хугацаатай зээлийг 5 хувийн хүүтэйгээр олгохоор журамд тогтоосон.

Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар оролцогч банкуудад нийт 11.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 1 хувийн хүүтэйгээр арилжаалан тухайн банкуудад мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж, эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд энэхүү үнэт цаасыг 2016 онд төлж барагдуулсан.

"Сайн хашаа" хөтөлбөр

Хот, суурин газрын гэр хорооллыг хэсэгчилсэн болон бие даасан инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх замаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын зүгээс "Сайн хашаа" хөтөлбөрийг 2016 онд хэрэгжүүлсэн бөгөөд Засгийн газрын 2016 оны 314 дүгээр тогтоолоор өмнө нь 2016 оны 252 дугаар тогтоолоор баталсан "Сайн хашаа" хөтөлбөрийн зээлийн ерөнхий журмыг шинэчлэн баталсан.

Зээлийн журамд заасны дагуу иргэнд 5 болон 10 хувийн хүүтэй зээл олгож, зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор оролцогч банкуудад нийт 11.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 1 хувийн хүүтэйгээр арилжаалж эх үүсвэрийг шийдвэрлэсэн бөгөөд энэхүү үнэт цаасыг 2016 онд төлж барагдуулсан.

“Сайн хувьцаа” хөтөлбөр

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн 1072 ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр нь Засгийн газарт худалдах хүсэлтээ илэрхийлсэн иргэдээс хувьцааг нь тодорхой үе шаттайгаар худалдан авч, эдийн засгийн эргэлтэд оруулах харилцааг зохицуулахаар Засгийн газрын зүгээс “Сайн хувьцаа” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Эхний ээлжид иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцаанаас 322 ширхэг хувьцаагаа худалдах хүсэлтэй иргэдийн хувьцааг Засгийн газар шууд худалдан авах, уг арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай эх үүсвэр (шууд худалдан авах зардал болон банкуудад өгөх шимтгэлийн зардал)-ийг Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах замаар бүрдүүлэхийг даалгасны дагуу иргэдийн хувьцаагаа худалдах хүсэлтийг 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс авч эхэлсэн бөгөөд хүсэлт гаргасан өдрөөс долоо хоногийн давтамжтайгаар 3 хувааж хувьцааны төлбөрийг олгосон.

Сангийн яамны зүгээс хүсэлт гаргасан иргэдийн тоон мэдээллийг Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас авах замаар шаардлагатай эх үүсвэрийг долоо, долоо хоногоор тооцож, улмаар Төрийн банк болон Хаан банктэй гэрээ байгуулан Засгийн газрын дотоод үнэт цаас эзэмшүүлэх, Монголбанкнаас тухайн өдөртөө багтаан Засгийн газрын дотоод үнэт цаасыг мөнгөжүүлэх замаар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, тус ажлыг зохион байгуулсан.

Дээрх үйл ажиллагааны дагуу 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдөр 123.0 тэрбум төгрөг, 6 дугаар сарын 24-ний өдөр 125.0 тэрбум төгрөг, 7 дугаар сарын 5-ны өдөр 126.0 тэрбум төгрөг, нийт 374.0 тэрбум төгрөгийн 15 жилийн хугацаатай, 1 хувийн хүүтэй Засгийн газрын дотоод үнэт цаасыг гаргаж, эх үүсвэр бүрдүүлсэн байдаг.

6.2. Засгийн газрын дотоод үнэт цаасны өнөөгийн нөхцөл байдал

Төсвийн сахилга батыг сайжруулах, Засгийн газрын өрийн багц дахь өндөр хүүтэй, богино хугацаатай өрийн хэмжээг бууруулах зорилгын хүрээнд 2017 оны 10 дугаар сард дотоод үнэт цаасны арилжааг зогсоож, 370.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдаж авах, шинээр дотоод үнэт цаас гаргалгүй, үнэт цаасны үлдэгдлийг хуваарийн дагуу төлж барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 2016 онд 5.8 их наяд төгрөгтэй тэнцэж байсан Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 517.7 тэрбум төгрөг болж, 2016 оны жилийн эцсийн үлдэгдлээс даруй 91.7 хувиар буурсан байна.

Засгийн газрын үнэт цаасны арилжааг Монголбанкаар дамжуулан арилжаалснаар анхдагч зах зээл дэх арилжааны банкнаас бусад оролцогчдын оролцоо хязгаарлагддаг тул шударга өрсөлдөөнт байдлаар үнэт цаасны хүү тогтох

боломж дутмаг байдаг сул талтай байсан. Түүнчлэн энэхүү үнэт цаасны үлдэгдлийн 90 орчим хувь нь арилжааны банкуудад ноогдож байв.

Дээрх шалтгаануудын улмаас Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжаа 2017 оноос эхлэн зогсож, дахин арилжаа хийгдээгүй бөгөөд 2022 онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хууль, "Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам"-ыг үндэслэн нийт 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг дотоодын аж ахуйн нэгжүүдэд гаргаж, 2022 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлээд байна.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2023 онд Засгийн газрын дотоод үнэт цаасыг Монголын Хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, мөн Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг дэмжих зорилгоор Тендерийн барьцааны зориулалттай дотоод үнэт цаас гаргах, үүнтэй холбоотой журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, арилжааны дэд бүтцийг сонгох зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Цаашид Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг мэргэжлийн хөрөнгө оруулагч, иргэд, аж ахуй нэгжийн оролцоог бүрэн хангах байдлаар нээх, үнэт цаасны оролцогчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх олон нийтэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчдын бааз суурь нэмэгдэж, Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зэрэг давуу талуудтай болно.

6.3. Өрийн бичиг/Вексель

Өмнөх онуудад ажил нь хийгдсэн боловч төсвөөс санхүүжилтээ авч чадаагүй үлдэгдэл төлбөр бүхий төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2015 оноос вексель бичиж эхэлсэн ба 2015 онд нийт 164.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын векселийг аж ахуйн нэгжүүдэд олгосон байдаг.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтэд зориулан 2016 онд Засгийн газрын 2015 оны 282 дугаар тогтоолын дагуу 1.0 тэрбум төгрөгийн вексель, Засгийн газрын 2016 оны 72 дугаар тогтоолын дагуу нийт 142.9 тэрбум төгрөгийн вексель, концессын гэрээний төлбөрт 335.0 тэрбум төгрөгийн вексель, татварын урьдчилгаа төлбөрт 54.0 тэрбум төгрөгийн вексель, нийт 532.9 тэрбум төгрөгийн вексель бичигдсэн.

"Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үлдэгдэл, "барих-шилжүүлэх" концессын гэрээний эргэн төлөлтийг векселиэр баталгаажуулахгүй байхаар Засгийн газарт даалгасны дагуу 2017 оноос хойш шинээр вексель бичигдээгүй бөгөөд 2016 онд 390.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 23.7 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр, 2017 онд 307.2 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 46.0 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг төлснөөр векселийн үлдэгдэл төлбөргүй болсон.

6.4. Барих-шилжүүлэх төрлийн концесс

Улсын төсвөөс 2014-2017 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 2.3 их наяд төгрөгтэй тэнцэх 40 концессын гэрээ болон орон нутгийн төсвөөс 2013-2016 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 133.4 тэрбум төгрөгтэй тэнцэх 50 концессын гэрээ тус тус байгуулагдсан байна.

"Барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээ байгуулагдсан дүнгээр Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг өсгөн, ирэх онуудын төсөвт ирэх төлбөрийн дарамт эрс нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолоор барих-шилжүүлэх концессын гэрээг дахиж байгуулахгүй байх, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл, арга хэмжээг зогсоох шийдвэр гарсан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 18.8-д "Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдох"-оор хуульчлагдсан бөгөөд мөн хуулийн 40.7-д "Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ" гэж заасан. Энэ хүрээнд Сангийн яамны зүгээс концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч Засгийн газрын өрд бүртгэж байна.

Хүснэгт 6. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, 2022.06.30, тэрбум ₮

"Барих-шилжүүлэх" концесс	Төслийн тоо	Гэрээний дүн	2022.06.30	
			Дүн	Эзлэх хувь
Улсын төсөв	10	1,286.1	470.1	99.91%
Гүйцэтгэл 100%	9	990.2	346.0	73.54%
Гүйцэтгэл 50-99%	1	295.9	124.1	26.38%
Орон нутаг	2	0.7	0.4	0.09%
Баянхонгор аймаг	1	0.04	0.02	0.01%
Ховд аймаг	1	0.60	0.34	0.07%
НИЙТ	12	1286.8	470.5	100.00%

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 673.9 тэрбум төгрөг байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 470.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 10 гэрээний үлдэгдэл 470.1 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 2 гэрээний үлдэгдэл 0.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

---oOo---